МЭДЭЭ · 2023 оны 4-р сарын 17

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА ӨНГӨРСӨН 7 ХОНОГТ НИЙТ 324 ХЭРЭГТ ЯЛЛАХ ДҮГНЭЛТ ҮЙЛДЭН ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЖЭЭ



Прокурорын байгууллага өнгөрсөн долоо хоногт буюу 2023 оны 4 дүгээр сарын 10-наас 14-ний өдрүүдэд хэрэг бүртгэлтийн 30.964, мөрдөн байцаалтын 2593 хэрэгт хяналт тавьж ажиллав.

Үүнээс Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 137, Өмчлөх эрхийн эсрэг 68, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 11, Бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 8, Хүрээлэн байгаа орчны эсрэг 7, Хүний амьд явах эрхийн эсрэг 5, Авлига, албан тушаалын эсрэг 1, Мөрийтэй тоглоом зохион байгуулах 3, Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх 1, нийт 324 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж шийдвэрлэлээ.

Яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн хэргээс дурдвал:

- Нийслэлийн прокурорын газраас Архангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Ц нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, хяналт шалгалт явуулах албаны чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байхын тулд бусдаас 37.000 ам.долларыг бэлнээр хахуульд авсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 22.4 дугаар зүйлийн 4-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн, Архангай аймаг дахь

сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

- Дархан-Уул аймгийн прокурорын газраас иргэн Н, Б нар нь ашиг олох зорилгоор Скай зочид буудалд мөрийтэй тоглоом /покер/ зохион байгуулсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийн 1-т заасснаар яллах дүгнэлт үйлдэн, тус аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

- Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас иргэн В нь мөрдөн шалгах ажиллагааны явцад худал мэдүүлж, бусдыг гэмт хэрэг үйлдсэн гэж гүтгэсэн, гэрч Н-ыг өөрт нь болон гэр бүлийхэнд нь хүч хэрэглэхээр заналхийлж, сүрдүүлсэн гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1, 21.2 дугаар зүйлийн 2, 21.5 дугаар зүйлийн 1-т заасснаар яллах дүгнэлт үйлдэн, тус дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд тус тус шилжүүлсэн байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=tYyqyBEEFmY

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1824